

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1. Нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах, үг, өгүүлбэрийг хасах, хүчингүй болсонд тооцох болсон үндэслэл, шаардлага;

Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заасан.

Монгол Улсын НҮБ-д гишүүнээр элсэн Хүний эрхийн тунхаглалыг бүрэн хүлээн зөвшөөрч, улмаар “Иргэний болон улс төрийн эрхийн тухай”, зэрэг хүний эрхийн талаарх НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудын олон улсын 30 гаруй гэрээнд нэгдэн орж, хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх үйлсэд зохих амжилт олсоор ирсэн. Үүний хүрээнд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор баталсан “Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчдын талаарх үндсэн зарчмын тухай тунхаглал”-д тулгуурлан Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.² Уг хөтөлбөрийн 2.1.5-д дараах байдлаар тодорхойлсон:

- “зохих сан бий болгох, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах даатгалд хамруулах эдгээр гэмт хэргийн улмаас учирсан **хохирлыг нөхөн төлүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, эхний ээлжид хариуцагч нь тодорхойгүй, эсхүл төлбөрийн чадваргүй иргэдийн хохирлыг төр урьдчилан төлж, хариуцагчаар нөхөн төлүүлэх журмыг хуулиар тогтоон хэрэгжүүлж цаашид боловсронгуй болгоно.**

Гэмт этгээдийн үйлдсэн хэргийн улмаас бусдад учруулсан **хохирлыг нөхөн төлүүлэх нөхцөлийг бий болгох** үүднээс хоригдлыг ажлаар хангах, тэдний хийж гүйцэтгэсэн ажлын хөлсийг ижил төрөл, хэмжээний ердийн ажил, үйлчилгээний хөлс, үнэлгээний дунджаас багагүй байхаар тогтоохын зэрэгцээ тэдэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.” гэж заасан.

¹ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 оны №1

² “Монгол Улсад хүний эрхийн хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоол, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2003 он №42, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6265>

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан “Хохирол нөхөн төлүүлэх эрх”- ийг хангах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааны үндэс нь хохирлын төрөл, хэмжээг тогтоох, үнэлэх асуудал юм.

Харин Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас тодорхой төрлийн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтэл учирсан хохирогчид шүүхийн шийдвэр гарсны дараагаар нөхөн төлбөр олгох зохицуулалттай байна.

Түүнчлэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйл болон 10 дугаар зүйлд зааснаар санхүүжилтийн эх үүсвэр нь шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө, энэ хуульд заасан 18 зүйлийн гэмт хэрэгт гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөр, улсын төсөв байхаар заасан байна.

Гэтэл дээрх сангаас зөвхөн шүүхийн шийдвэр гарсны дараа хохирлын нөхөн төлбөрийг олгохоор заасан нь дээрх бодлогын баримт бичигтэй нийцэхгүй байгаа бөгөөд гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийг хангах, түүнийг нөхөн сэргээх байдал хангалтгүй байгаа үүднээс энэхүү харилцааг зохицуулах шаардлага үүссэн байна.

Иймд хүний зөрчигдсөн эрхийг хамгаалах механизмын нэг хэлбэр болох гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, үнэлэх, нөхөн төлүүлэх үндэсний тогтолцоо бүрдүүлэх нь тулгамдсан асуудал болсоор байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль нь 2019 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан бөгөөд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зохицуулалт нь анх 2007 онд Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль, 2006 оны 06 дугаар сарын 29-ний өдөр баталсан Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/-д 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн уг хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр орсон болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйл болон 10 дугаар зүйлд зааснаар санхүүжилтийн эх үүсвэр нь шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө, энэ хуульд заасан 18 зүйлийн гэмт хэрэгт гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөр, улсын төсөв байхаар заасан байна.

Гэтэл дээрх сангаас зөвхөн шүүхийн шийдвэр гарсны дараа хохирлын нөхөн төлбөрийг олгохоор заасан нь дээрх бодлогын баримт бичигтэй нийцэхгүй байгаа бөгөөд гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийг хангах, түүнийг нөхөн сэргээх байдал хангалтгүй байгаа үүднээс энэхүү харилцааг зохицуулах шаардлага үүссэн байна.

Иймд хүний зөрчигдсөн эрхийг хамгаалах механизмын нэг хэлбэр болох гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, үнэлэх, нөхөн төлүүлэх үндэсний тогтолцоо бүрдүүлэх нь тулгамдсан асуудал болсоор байна.

2.Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай;

Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлно:

-Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн нэрийг Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сан гэсэн өөрчлөлтийг тусгасан;

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.3-т заасан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн нэрийг Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сан гэж өөрчилсөн. Үүнтэй уялдуулан мөн хуулийн 10 дугаар зүйлийн гарчгийг Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сан гэж өөрчлөх томъёоллыг Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлд тусгасан. Ингэж нэрийг өөрчлөхдөө тухайн зүйлийг бүхлээр өөрчилж, санхүүжилтийн эх үүсвэрийг тогтвортой байлгах, шүүхийн шийдвэр гарахаас өмнө хохирлыг урьдчилан нөхөн барагдуулах шийдвэрийг гаргаж, нөхөн барагдуулах зэрэг зохицуулалтыг тусгасан болно.

- Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангаас олгох сангийн хөрөнгийн эх үүсвэрийг “гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг гэмт хэргийн хохирлыг барагдуулахад зарцуулах” зарчмыг үндэслэн нэмэгдүүлэх, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох зохицуулалтыг тусгасан;

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 болон 10 дугаар зүйлд заасан нийт 4 төрлийн санхүүжилтийн эх үүсвэрээр уг сан нь санхүүжихээр заасан байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө 6.1.1,
2. Хандив, тусламж 6.1.2,
3. Шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө 10.2.1,
4. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10.3-т заасан гэмт хэрэгт гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөр 10.2.2 болно.

Дээрх эх үүсвэрээр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10.3-т заасан 21 төрлийн гэмт хэргийн хохирогчийн хохирлыг бүрэн нөхөн барагдуулж чадах эсэх нь тодорхойгүй байна. Улсын Их Хурлаас 2006 оны 06 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчингүйд тооцсон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³ дугаар зүйлд нийт 10 төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгохоор заасан байсан. Харин уг сангийн санхүүжилтийн эх үүсвэрийг тус хуулийн 21³ дугаар зүйлийн 21³.1.1-д шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө; 21³.1.2-т замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө; 21³.1.3-т шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр энэ хуулийн 21³.2-т заасан /10 төрлийн гэмт хэргэг/ гэмт хэрэгт гэм

буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөр байхаар заасан байжээ.

Одоогийн дагаж мөрдөж байгаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т нийт 21 төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөрийг олгохоор өмнөх хуулиас 11 гэмт хэргээр өргөжүүлэн заасан байна. Харин уг сангийн санхүүжилтийн эх үүсвэрээс 1 төрлийн санхүүжилтийн эх үүсвэр буюу замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө төвлөрүүлэхийг хассан байна.

Хэдийгээр 2019 онд шинэчлэн батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хууль нь төрөөс нөхөн төлбөр олгох гэмт хэргийн төрлийг нэмэгдүүлсэн сайн талтай боловч, санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулсан нь муу талтай болжээ.

Монгол Улсын хэмжээнд жилдээ дунджаар 30 гаруй мянган гэмт хэрэг гардаг бөгөөд байнгын өсөлттэй байдаг. Тухайлбал, 2022 онд 35340³, 2023 онд 35574, 2024 онд 44763 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна.⁴ Энэхүү гэмт хэргийн өсөлттэй уялдаад нөхөн төлөх хохирлын хэмжээ ч нэмэгдэнэ.

Харин Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2-т заасан санхүүжилтийн эх үүсвэр нь нэр төдий эх үүсвэр болно. Өөрөөр хэлбэл, дээрх 2 санхүүжилтийн эх үүсвэрийн дагуу уг санд улсын төсөв болон иргэд, байгууллагаас хандив, тусламжаар санхүүжилт төвлөрдөггүй байна. Харин Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.1 болон 10.2.2-т заасан санхүүжилтийн эх үүсвэрээр тогтмол санхүүжиж байна. Тухайлбал, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2-т заасан эх үүсвэрээр буюу хохирол барагдуулсан төлбөрт 2012 оноос 2017 онд 78.558.114 төгрөг, 2018 онд 102.756.688 төгрөг, 2019 онд 155.968.714 төгрөг, 2020 онд 128.351.753 төгрөг, 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 218.668.421 төгрөг, 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар 205.857.957 төгрөг, 2023 оны 134.714.606 төгрөг, 2024 онд 195.333.595 төгрөг, 2012 оноос 2024 оныг дуусталх хугацаанд нийт 1.902.551.419 буцаан төвлөрүүлээд байна.

Харин Засгийн газрын тусгай сангийн тухай 10 дугаар зүйлийн 10.2.1-д заасан Шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн төвлөрүүлэлтийг авч үзвэл 2012 онд 29.345.416, 2013 онд 469.314.234, 2014 онд 599.836.781, 2015 онд 135.228.483, 2016 онд 181.999.486, 2017 онд 573.902.686, 2018 онд 2.620.280.973, 2019 онд 3.403.201.150, 2020 онд 3.893.420.508, 2021 онд 3.178.224.732, 2022 онд 4.016.783.978, 2023 онд 7.282.053.286 төгрөг байна.⁵

³ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, 2022 онд, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл

⁴ Цагдаагийн байгууллагад 2024 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ, тайлан 2024 он, Цагдаагийн ерөнхий газар,

<https://strategy.police.gov.mn/resource/information/File/2025/01/06/6c3do9phniwnbgiv/%D0%A5%D1%8D%D1%80%D1%8D%D0%B3.pdf>

⁵ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйл /гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан/ болон түүнд холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 2025 он

Тухайлбал, 2023 онд шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн төвлөрүүлэлтээс 7.2 тэрбум, хохирол барагдуулсан төлбөрөөс 134.7 сая төгрөг, нийт 7.4 тэрбум төгрөгийг уг санд төвлөрүүлсэн байна. Энэ нь өндөр дүнтэй хөрөнгийг санд 1 жилд төвлөрүүлж байгаа боловч үйлдэгдэж буй гэмт хэрэг, нөхөн төлөх хохирлын хэмжээтэй харьцуулахад хангалттай биш байна.

Түүнчлэн шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө орлого нь тогтмол биш бөгөөд торгох ял оногдуулсан тоотой шууд хамааралтай юм. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд оруулж байгаа шүүхийн шийдвэр гарснаас үл хамааран шаардлагатай тохиолдолд барагдуулах хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ зэрэгтэй харьцуулахад санхүүжилтийн эх үүсвэр тогтмол биш байх талтай байна. Хуульд оруулах өөрчлөлтөөр мөн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгахад шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хэлмэрчид төлөх зардал зэргийг нэмж санхүүжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан болно. Иймд тодорхой хэмжээгээр санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх, тогтмолжуулах шаардлага зүй ёсны болно.

Мөн “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай” Палермогийн протоколд зааснаар гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг гэмт хэргийн хохирлыг барагдуулахад зарцуулахаар заасан байдаг. Гэвч Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 3-т “Хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирлоос илүү гарсан тохиолдолд **улсын төсөвт шилжүүлнэ.**” гэж заасан байна. Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 4-т “Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна.” гэж заасан байна. Үүнээс үзэхэд гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулснаас үлдсэн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлэхээр заасан.

Мөн үндэслэлгүйгээр хөрөнгөжих болон авлигын гэмт хэрэгт бодит хохирол гарахгүй байх боломжтой бөгөөд тухайн авлигын гэмт хэргээс хураагдсан эд зүйлийг улсын төсөвт шууд шилжүүлэх эрх зүйн зохицуулалттай байна. Гэтэл Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох санд хөрөнгө төвлөрүүлсэн тоо мэдээнээс үзэхэд улсын төсвөөс энэ санд хөрөнгө ордоггүй байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хохирлыг барагдуулах зарчимтай хөрөнгө улсын төсвөөр дамжин уг санд ордоггүй байна.⁶

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, сүүлийн 5 жилд хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ

⁶ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйл /гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан/ болон түүнд холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 2025 он

авагдсан хүнээс 22,4 тэрбум төгрөгийг улсын орлогод төвлөрүүлсэн байна.⁷ Түүнчлэн Авлигатай тэмцэх газраас 2 их наяд 374 тэрбум төгрөгийн авлигын гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулсан байна.

Үүнээс үзэхэд хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээнээс болон авлигын гэмт хэргээс учирсан хохирлыг Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох санд төвлөрүүлэн хохирлыг барагдуулах нь бүрэн боломжтой гэж үзэж байна.

Иймд хүний зөрчигдсөн эрхийг хангах, олон улсын конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх, олон улсын хүний эрхийн тайланд дурдсан зөвлөмжийг биелүүлэх хүрээнд Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, тухайлбал, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, авлига авах гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг уг санд төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзэн Засгийн газрын тусгай сангийн 10 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгасан болно.

- Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангийн хөрөнгөөр шүүхийн шийдвэр гарахаас өмнө нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн;

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд хүнийг санаатай алах, хүний биед хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах, хүчиндэх, дээрэмдэх, террорист үйлдэл хийх, хүн барьцаалах зэрэг нийт Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 21 төрлийн гэмт хэргийн хохирогчид зөвхөн шүүхийн шийдвэр гарсны дараа тодорхой төрлийн бодит хохиролд нөхөн төлбөр олгохоор заасан байна. Тухайлбал, эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого зэрэг болно.

Түүнчлэн шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй, хохирлын нөхөн төлбөрийг шүүхийн шийдвэрээр тогтоогоогүй, шүүхийн шийдвэр гараагүй байхад хохирогчид хүнд гэмтэлд яаралтай эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай байвал Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас төлбөр олгох хууль зүйн хувьд боломжгүй байна. Тодруулбал, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдохоор заасан байна. Ингэж заавал шүүхийн шийдвэр гарсны дараа нэн шаардлагатай нөхөн төлбөрийг олгохоор байгаа нь хохирлыг хурдан шуурхай нөхөн төлж, зөрчигдсөн эрхийг сэргээх үндсэн зорилгодоо тэр бүр нийцэхгүй байдаг. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн хохирогчид хохирлын хор хохирол, хор уршгийн нэн яаралтай арилгахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны урт удаан процессыг дуусгаж, шүүхийн шийдвэр гарахаас өмнө шаардлагатай байдаг. Тухалбал, 2017, 2018, 2019 онуудад гарсан нийт гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн байдлыг тоо баримтыг харахад 1/3 хувь нь л шүүхээр тухайн ондоо шийдвэрлэгдсэн байна. Тэгэхээр ихэнх хэрэг тухайн ондоо шүүхээр

⁷ Хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээний сүүлийн 5 жилийн хэрэгжилтын тайлан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2023 он

шийдэгдэхгүйгээс болж хохирогчид олгох нөхөн төлбөрийн хугацаа тэр хэрээр хойшлоход хүрч байгаа нь харагдаж байна.⁸

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгаанд дурдсанаар Сэлэнгэ аймгийн сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 2024/ШЦТ/209 дугаартай Эрүүгийн хуулийн 11.1.1 дүгээр зүйл буюу хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэргийн шүүхийн шийдвэрт хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдсон этгээдээс эмчилгээний зардалд 3,789.240 төгрөгийг нэхэмжилсэн бөгөөд шүүгдэгч нь мөрдөн шалгах ажиллагааны үеэр 3.789.240 төгрөг төлсөн талаар дурдсан байна.⁹

Шүүхийн 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 2024/ШЦТ/209 дугаартай тогтоолын тогтоох хэсгийн 5-д Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д зааснаар шүүгдэгч шүүгдэгчээс сэтгэцэд учирсан хохирол 2.640.000 төгрөгийг гаргуулж хохирогчийн хууль ёсны төлөөлөгчид олгосугай, 6-д насанд хүрээгүй хохирогч нь энэ хэргийн улмаас цаашид эмчлэгдэх бол нотлох баримтаа бүрдүүлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар нэхэмжлэх эрхийг нээлттэй үлдээсүгэй гэж тогтоосон байна. Тодруулбал, мөрдөн байцаалтын явцад болон шүүх хуралдааны үед бодит хохирол болох эмчилгээний зардлыг төлж барагдуулсан байна. Үүнээс үзэхэд гэмт хэргийн хохирогчид нэн яаралтай эмчилгээний зардал шаардлагатай болох бөгөөд энэ нь тухайн гэмт хэргийн зүйлчлэл хүндрэхээс сэргийлж болох байна.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.¹⁰ Уг хөтөлбөрийн 2.1.5-д “зохих сан бий болгох, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах даатгалд хамруулах эдгээр гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, эхний ээлжид хариуцагч нь тодорхойгүй, эсхүл төлбөрийн чадваргүй иргэдийн хохирлыг төр урьдчилан төлж, хариуцагчаар нөхөн төлүүлэх журмыг хуулиар тогтоон хэрэгжүүлж цаашид боловсронгуй болгоно.” гэж заасан байдаг.

Харин Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тодорхой гэмт хэргийн хохирогчид учирсан хохирлыг төр нөхөн барагдуулахаар хуульчилсан нь дэвшилттэй боловч учирсан хохирлыг бодит хохирлоор хязгаарласан, зөвхөн шүүхийн шийдвэр гарсны дараа нөхөн төлбөр олгохоор заасан, цөөн тооны гэмт хэргийн хохирогчоор хязгаарласан, хохирлыг зөвхөн эдийн хохирлоор хязгаарласан нь иргэдийн “бодит хохирлыг барагдуулах” зарчимд нийцээгүйн дээр Монгол Улсын Үндсэн хуулиар иргэнд олгосон “хохирол нөхөн төлүүлэх” эрх, “хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчимд нийцэхгүй байна.

Түүнчлэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т Эрүүгийн хуульд заасан нийт 21 төрлийн гэмт хэргийн хохирогчид Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас нөхөн төлбөр олгохоор заасан болно. Харин

⁸ Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх хуулийн төслийг боловруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах” судалгааны ажлын тайлан, 2019 он, Хууль зүй, дотоод хэргийн яам

⁹ Сэлэнгэ аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, 2024.10.07, 2024/ШЦТ/209, https://shuukh.mn/single_case/109314?daterange=2024/01/01%20-%202024/10/08%20&id=1&court_cat=2&bb=1

¹⁰ “Монгол Улсад хүний эрхийн хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоол, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2003 он №42, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6265>

Хууль зүй, дотоод хэргийн яам болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тайлан мэдээнээс үзэхэд Эрүүгийн хуульд заасан дээрх 21 төрлийн гэмт хэргээс зөвхөн 5 төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөрийг уг сангаас зөвхөн шүүхийн шийдвэр гарсны дараа нийтлэгээр олгодог байна.

Тухайлбал, 2002-2023 оны хооронд Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас олгосон төлбөр төлөгч нарын 73.88 хувь нь Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 10.1 /91.1/-т заасан хүн алах, 16.86 хувь нь Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 11.1 /96.1, 96.2/ буюу хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, 0.41 хувь нь Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 11.4-т заасан хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах, 8.85 хувь нь Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 12.1 /126.1/-т заасан хүчиндэх гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрт олгосон байна.

Харин Эрүүгийн хуульд заасан бусад 16 төрлийн гэмт хэрэг нь 1 дүгээрт төдийлөн гардаггүй, 2 дугаарт уг гэмт хэргийн хохирогч нь тэр бүр хохирлоо уг сангаас нөхөн төлбөр авах хүсэлт гаргадаггүй, 3 дугаарт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирлоо бүрэн барагдуулдаг байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 13.2 дугаар зүйл/Хүн хулгайлах/, 13.3 дугаар зүйл /Хүн барьцаалах/, 19.3 дугаар зүйл/Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 29.1 дүгээр зүйл /Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/, 29.8 дугаар зүйл /Террор үйлдэх/, 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/, 15.3 дугаар зүйл /Хүний цус, эс, эс эрхтнийг хууль бусаар авах/, 15.5 дугаар зүйл /Хууль бусаар үр хөндөх/, 16.3 дугаар зүйл /Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх/, 16.6 дугаар зүйл /Хүүхэд худалдах/, 16.7 дугаар зүйл /Хүүхэдтэй хэрцгий харьцах/ зэрэг 11 төрлийн гэмт хэрэг сүүлийн 20 жилийн хугацаанд, түүнчлэн Эрүүгийн хуульд орсон боловч огт бүртгэгдээгүй байна.

Харин Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйл /Хүнийг хүчээр алга болгох/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/, 16.1 дүгээр зүйл /Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/ гэмт хэрэг нь ховор гардаг бөгөөд хохирогч нь тус сангаас нөхөн төлбөр авах хүсэлт гаргаагүй байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 онд өгсөн чиглэлийн дагуу Засгийн газрын тусгай сангуудад шалгалт хийсэн байна. Гэвч иргэд үүнийг мэддэггүй учир төрөөс хохирол барагдуулах тогтолцоо харилцан адилгүй явагдаж, зөвхөн өргөдөл гаргасан иргэнд олгож иржээ. Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдох бөгөөд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай нь тогтоогдсон этгээдээр санд буцаан төвлөрүүлэхээр хуульчилсан байдаг.

Нөхөн төлбөр хүсэх өргөдлийн маягтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас авах бөгөөд хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас авах бөгөөд хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр болон гүйцэтгэх хуудасны хуулбар, өргөдөл гаргагч иргэний баримт бичгийн хуулбар хохирлыг ялтан буюу түүний хууль ёсны төлөөлөгч барагдуулаагүй, эсвэл дутуу барагдуулсныг нотлох баримтыг хавсаргах ёстой. Энэ тохиолдолд гэмт этгээд тодорхойгүй эсхүл цагаатгагдсан тохиолдолд төрөөс хохирлыг барагдуулах боломжгүй байдлаар хуульчлан зохицуулж, хохирогч хохирч үлдэх эрсдэлийг бий болгож байна. Хүний зөрчигдсэн эрхийг сэргээх асуудал нь эрх зүйн

харилцаанд юу юунаас илүү чухал зүйл билээ. Гэвч гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо барагдуулж, хор уршгаа нөхөн төлүүлж чадахгүй байгаа нөхцөл хэвээр байна.

Гэмт хэргийн улмаас хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учирч түүнийг нөхөн барагдуулахад шударга ёсны зарчмыг баримтлах учиртай. Шударга ёсны мөн чанар нь нийгмийн харилцаанд оролцогчид эрх тэгш байх явдлаар илэрдэг. Гэвч гэмт хэргийн улмаас нөхөн төлбөр авах сангаас хохирогчид эрх тэгш байдлаар нөхөн төлбөрийг авч байгаа эсэх нь маш эргэлзээтэй байна.¹¹

Иймд дээрх шаардлагын үндсэн дээр ялангуяа Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.4 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/, 13.3 дугаар зүйл /Хүн барьцаалах/, 15.3 дугаар зүйл /Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах/, 15.5 дугаар зүйл /Хууль бусаар үр хөндөх/, 16.1 дүгээр зүйл /Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах/, 16.3 дугаар зүйл /Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх/, 16.6 дугаар зүйл /Хүүхэд худалдах/, 16.7 дугаар зүйл /Хүүхэдтэй хэрцгий харьцах/, 16.11 дүгээр зүйл /Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/, 29.8 дугаар зүйл /Террорист үйлдэл хийх/-д заасан гэмт хэргийн улмаас хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан хохирогчид, нас барсан хүний хохирогчоор тогтоогдсон хүнд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарахаас өмнө хохирлыг уг сангаас санхүүжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан болно.

Шүүхийн шийдвэр гарахаас өмнө хохирлыг барагдуулах журмын хүрээнд хохирлын хэмжээг тооцохдоо хохирсон этгээдийн нэхэмжлэлд дурдсан хэмжээ, дотоодын эмнэлгийн байгууллагын төлбөрийн баримт үндэслэн хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан аргачлалыг баримтлахаар төсөлд тусгасан.

Харин шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан хэмжээгээр олгох зохицуулалтыг хэвээр хадгалсан болно.

- Шүүхийн шийдвэрийг үндэслэн, эсхүл шүүхийн шийдвэр гарахаас өмнө Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангийн санхүүжилтээр олгох Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн жагсаалтыг ялгамжтай байдлаар тодорхойлсон;

Гэмт хэргийн улмаас хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учирч түүнийг нөхөн барагдуулахад шударга ёсны мөн чанар нь нийгмийн харилцаанд оролцогчдод хуулийн өмнө эрх тэгш байх явдлаар илэрдэг. Ханс Кельзен “хүний эрх чөлөөг баталгаажуулсан нийгмийн тогтолцоо шударга ёсны үндэс мөн. Шударга ёс бол нийгэм дэх аз жаргал” хэмээн бичсэн байна.¹²

Гэвч төрөөс зөвхөн тухайлан заасан гэмт хэргийн улмаас учирсан хохиролд нөхөн төлбөр олгож, хохирогчдод харилцан адилгүй нөхөн төлбөрийг олгож байна. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 132 дугаар тогтоолын

¹¹ Хохирлын сангийн тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан 2021 он

¹² Хохирлын сангийн тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан 2021 он. Хуудас 37

хавсралтаар баталсан “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчдод төрөөс нөхөн төлбөр олгох журам”-д зааснаар 2011 оны 1 дүгээр сарын 1-ээс хойш үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчдод нэг удаа нөхөн төлбөр олгохоор тухайлбал, хүнийг санаатай алах, бусдын бие махбодод хүнд гэмтэл санаатай учруулах, хүн хулгайлах, хүнийг барьцаалах, хууль бусаар хорих, хүн худалдаалах, хүчиндэх, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, зандалчлах, терроризм, эрүү шүүлт тулгах зэрэг 8 төрлийн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан /хүчингүй болсон 2002 оны Эрүүгийн хуулийн заалт/ хохирогчдод нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21.3.2 дахь заалтад хуульчилсан байсан ба 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох сангаас хүнийг алах, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, хүчиндэх, хүн барьцаалах, хүнийг хууль бусаар хорих, хүчээр алга болгох, дээрэмдэх, төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах, эрүү шүүлт тулгах, түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх, террор үйлдэх гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дор дурдсан хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна” гээд гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй, хохирогчийн бие махбодод хүнд гэмтэл учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөр олгохоор заасан бөгөөд Засгийн газрын тусгай сангийнх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 21 дүгээр зүйлд эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого” -ыг хамааруулан нөхөн төлбөр олгохоор 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.¹³

Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарахаас өмнө бодит хохирлоо авч болох нийт 13 төрлийн гэмт хэргийн төрлийг ялгамжтай байдлаар хуулийн төсөлд тусгасан болно. Энэ нь Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.4 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/, 13.3 дугаар зүйл /Хүн барьцаалах/, 15.3 дугаар зүйл /Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах/, 15.5 дугаар зүйл /Хууль бусаар үр хөндөх/, 16.1 дүгээр зүйл /Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах/, 16.3 дугаар зүйл /Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх/, 16.6 дугаар зүйл /Хүүхэд худалдах/, 16.7 дугаар зүйл /Хүүхэдтэй хэрцгий харьцах/, 16.11 дүгээр зүйл /Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/, 29.8 дугаар зүйл /Террорист үйлдэл хийх/-д заасан гэмт хэрэг болно. Эдгээр гэмт хэргийг тухайн гэмт хэргийн хохирогчийн бие махбод болон сэтгэцэд хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан байхыг шаарддаг материаллаг бүрэлдэхүүнтэй, түүнчлэн хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийг чухалчлан авч үзэн бие махбодид учирсан гэмтэл, сэтгэцэд учирсан хор уршгийг яаралтай эмчлэх, сэргээн засах шаардлага зэргийг үндэслэн сонгон хуулийн төсөлд тусгайлан оруулсан болно. Түүнчлэн хуулийн төслийг боловсруулах явцад хийгдсэн хэрэгжилтийн үр дагавар, үр нөлөөний судалгаа зэрэгт дурдсан гадаад орны туршлагыг мөн харгалзан үзсэн болно.

¹³ Хохирлын сангийн тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан 2021 он,

- Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр “Тусгай сангийн хөрөнгөөр гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийг хохирогчид шууд олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн;

Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангийн хөрөнгөөр гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр хохирогчид шууд олгохоор тусгасан. Энэ нь зөвхөн шүүхийн шийдвэр гарахаас өмнө буюу Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “10.4. Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.4 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/, ... 29.8 дугаар зүйл /Террорист үйлдэл хийх/” нийт 15 гэмт хэргийн хохирогчийн хохирлыг нөхөн барагдуулах болон шүүхийн шийдвэр гарсан ч нөхөн төлбөрийг шууд олгож чадахгүй байгаа төлбөрийн чадваргүй этгээдэд адил хамаарна. Тодруулбал, шүүхийн шийдвэр гарахаас өмнө нэн шаардлагатай тухайлбал эмчилгээний зардлыг гаргуулан авахад дотоодын эмнэлгийн байгууллагын төлбөрийн баримтад үндэслэн батлагдсан аргачлалын дагуу тогтоосон төлбөрийн хэмжээгээр тухайн сангийн тэргүүн буюу Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар хохирогчид олгох юм. Харин шүүхийн шийдвэр гарсны дараа гэмт буруутай этгээдээс хохирлыг гаргуулж, тухайн санд төвлөрүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэхээр хуулийн төсөлд мөн тусгасан.

Түүнчлэн шүүхийн шийдвэр гарсны дараа олгох нөхөн төлбөрийг хуулийн дагуу хэрэгжүүлэхэд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан ойлгомжгүй, практикт хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зохицуулалтыг хуулийн төсөлд тодорхой болгож тусгасан.

Энэ нь Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зарцуулалт нь гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгохоор заасан бөгөөд дээрх хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.2-т заасан хэлбэрээр олгох боломжгүй юм. Тодруулбал, уг сангаас ямар нэг ажил, үйлчилгээг гүйцэтгэсэн асуудал энд яригдахгүй болно.

Нөгөө талаас дээрх хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.1 /эмчилгээний зардал;/, 10.3.2./оршуулгын зардал;/ 10.3.3. /хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого./ зэрэг нь ажил, үйлчилгээнд огт хамаарахгүй байна. Энэхүү зохицуулалтад заасан “бараа, ажил, үйлчилгээ” гэдэг ойлголтыг эдийн засгийн утгаар ойлгох бөгөөд үүнийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.4, 4.1.20-д тус тус нэр томъёог дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйл:

-4.1.1-д "ажил" гэж барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг барих, засварлах, өргөтгөх, буулгах, шинэчлэх, геологийн судалгаа хийх болон тэдгээрт холбогдох тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, турших, тохируулах зорилгоор хүн хүч, машин техник, тоног төхөөрөмж, материал, технологийг хослуулан ашиглаж гүйцэтгэх ажлыг болон түүнийг дагалдан нийлүүлэх барааг;

- 4.1.4-т "бараа" гэж эдийн засгийн ач холбогдол, үнэ бүхий худалдах, солилцох, түрээслэх боломжтой эд юмс, бэлэн шийдэл бүхий биет бус хөрөнгө болон тухайн барааг дагалдан үзүүлэх ажил, үйлчилгээг;

- 4.1.20-д "үйлчилгээ" гэж энэ хуулийн 4.1.1-д заасан ажил гүйцэтгэхэд хамаарахгүй угсралт, суурилуулалт, туршилт, тохируулгын, эсхүл тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйл ажиллагааг; гэж тодорхойлсон.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д "Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмыг Засгийн газар батална." гэж заасны дагуу Засгийн газрын 2020 оны 220 дугаар тогтоолын хавсралтаар "Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам"-ыг баталсан. Уг журмаар Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг хохирогчид олгох процесс ажиллагааг журамласан.

Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмын 5-д зааснаар хохирогчоос гаргасан нөхөн төлбөр авах хүсэлтийг хянасны үндсэн дээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар нөхөн төлбөрийг олгохоор шийдвэрлэх бөгөөд хохирогчийн банкны хадгаламжийн, эсхүл харилцах дансанд шилжүүлэхээр заасан байна.

Үүнээс дүгнэхэд Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.2-т заасан санхүүжилтийн хэлбэр нь Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн санхүүжилтийн хэлбэртэй нийцэхгүй байх бөгөөд үүнтэй холбоотой харилцааг Засгийн газрын 2020 оны 220 дугаар тогтоолоор батлагдсан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмаар нөхөн зохицуулж байна.

Дээрх хууль болон журмын дагуу 2012-2023 оны хооронд Хууль зүй, дотоод хэргийн сайдын нийт 30 удаагийн тушаалаар 516 хохирогч иргэнд 3.251.469.994 /гурван тэрбум хоёр зуун тавин нэгэн сая дөрвөн зуун жаран есөн мянга есөн зуун ерэн дөрөв/ төгрөгийн¹⁴ нөхөн төлбөрийг "Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан"-аас олгосон байдаг. Ингэж шийдвэр гаргаж олгохдоо дээрх журамд заасны дагуу олгохоор шийдвэрлэсэн нөхөн төлбөрийн хэмжээгээр хохирогчийн банкны дансанд шилжүүлдэг байна.

Тодруулбал, Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан " 23.7. ... 5.3.4-т заасан тусгай сангийн хөрөнгөөр гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр хохирогчид шууд олгоно."

"10.6.Энэ хуулийн 10.3-т заасан хохирлын хэмжээг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан хэмжээгээр, 10.4-т заасан хохирлын хэмжээг хохирогчийн нөхөн төлбөр гаргуулах нэхэмжлэл, дотоодын эмнэлгийн байгууллагын төлбөрийн баримтад үндэслэсэн Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангийн удирдах зөвлөлийн дүгнэлтээр тус тус тодорхойлогдоно.

10.7.Энэ хуулийн 10.4-т заасан хохирлын хэмжээг хохирогчийн нөхөн төлбөр гаргуулах нэхэмжлэл, дотоодын эмнэлгийн байгууллагын төлбөрийн баримтад

¹⁴ Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмын хэрэгжилтийн танилцуулга, 2023 он, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

үндэслэсэн тогтоох аргачлалыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

10.8.Энэ хуулийн 10.4-т заасан гэмт хэргийн хохирогч нь шүүхийн шийдвэр гарахаас өмнө нөхөн төлбөрөө аваагүй бол энэ хуулийн 10.3-т заасны дагуу шүүхийн шийдвэрт заасан хэмжээгээр нөхөн төлбөрийг авч болно.

10.9.Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 3 болон Зөрчлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 3-т заасан хөрөнгө, орлогыг Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах санд хөрөнгө төвлөрүүлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж хуулийн төсөлд тусгасан.

- Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангийн удирдлага, зохион байгуулалтын оновчтой хэлбэр, хяналтын эрх зүйн орчныг бүрдүүлсэн;

Торгох ялын төлбөрийн 60 хувийг санд төвлөрүүлж байгаа ч шүүхийн шийдвэрээр тогтоогдсон торгох ялын төлбөрийг бүрэн хэмжээгээр төвлөрүүлж төсөвт оруулахаар зааж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, нөхөн төлбөр олгох ажлын явц, дүнг хагас жил тутам Засгийн газарт тайлагнах, нөхөн төлбөр олгоход шаардагдах хөрөнгийг хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад жил бүр тусган санхүүжүүлэхээр заасан байдаг. Гэвч тус тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, нөхөн төлбөр олгох ажлын явц болон төсөвт ялын төлбөрийг бүрэн хэмжээгээр төвлөрүүлж чадаж байгаа эсэхэд хяналт хангалтгүй гэж ээлжит хяналтаар тогтоогдсон байна.¹⁵

Тус хуулийн төсөлд Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангийн дүрэм, Удирдах бүрэлдэхүүн, уг сангаас гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмыг Засгийн газар батлах буюу тусгайлан журмаар зохицуулахаар тусгасан.

- Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангаас зарим төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд шаардлагатай зардлыг гаргах зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгахад шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хэлмэрчид төлөх зардал зэргийг уг сангаас санхүүжүүлэх зохицуулалтыг тусгасан;

Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангаас зарим төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд шаардлагатай зардлыг гаргах зохицуулалтыг тусгалаа. Тухайлбал, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгахад шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хэлмэрчид төлөх зардлыг санхүүжүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 3-т хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулахаар заасан бөгөөд Төсвийн тухай хуулийн дагуу төсөвт хуримтлагдан эргээд дараа жил Улсын Их Хурлаар хуваарилагддаг. Тодруулбал, хуваарилалт хийгдэж төсөвт суугдахдаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал нь тухайн жилдээ хүрэлцэхээргүй төсөвлөгддөг байна. Энэхүү төсвийн хангалтгүй хуваарилалтаас болж

¹⁵ Монгол улсын Сангийн яам. (2018) “Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох сан” – ийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгийн талаар

мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэх, орчуулга, хэлмэрчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах чадахгүйгээс хүний эрхийг зөрчигдсэн эрхийг сэргээхэд хүндрэл учирдаг. Иймд Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 3-т заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал зарцуулах зохицуулалтын дагуу Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангийн хөрөнгөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал болох шинжээчийн дүгнэлт гаргах, орчуулагч, хэлмэрчийн зардлыг санхүүжүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Ингэхдээ зөвхөн хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгахад шаардлагатай хохирлын үнэлгээ, шинжилгээ, лабораторийн зардлыг санхүүжүүлэхээр тусгасан. Тодруулбал, дээрх зардал нь бусад гэмт хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлаас өндөр байдаг тул шууд хууль сахиулах байгууллага дээр төсөвлөгддөг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлаас гаргах боломжгүй байдаг. Тухайлбал, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг дээр ялангуяа уул уурхайн гэмт хэрэг дээр хөндлөнгийн байгууллагаар хохирол тооцох, шинжээчийн дүгнэлтийн гаргуулахад 30 дээш сая төгрөгөөр гэрээ байгуулдаг байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг даган Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно. Эдгээр хуульд өөрчлөлт оруулахаар тусгасан зохицуулалт нь Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангийн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэхтэй холбоотой өөрчлөлт болно. Тухайлбал, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг “Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл /Мөнгө угаах/, Хорин хоёрдугаар бүлэг /Авлигын гэмт хэрэг/-т заасан гэмт хэргээс бусад гэмт хэргийн хураан авсан хөрөнгө, орлогыг улсын төсөвт төвлөрүүлж, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна. Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл /Мөнгө угаах/, Хорин хоёрдугаар бүлэг /Авлигын гэмт хэрэг/-т заасан гэмт хэрэгтэй холбоотойгоор хураагдсан хөрөнгө, орлогыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.3-т заасан тусгай санд төвлөрүүлнэ.” гэж өөрчлөн найруулж байна. Тодруулбал, Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангийн эх үүсвэрийг тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрээр хангах, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх хүрээнд Эрүүгийн хуульд заасан Мөнгө угаах болон Авлигын гэмт хэрэгт хураагдсан хөрөнгө, орлогыг уг санд төвлөрүүлж, гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулахад зарцуулах болно. Түүнчлэн Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Зөрчлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 3-т заасан хөрөнгө орлогыг мөн санд төвлөрүүлэхээр тусгасан болно.

----o0o----